



МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН  
ТУШААЛ

2018 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/19

Улаанбаатар хот

Г Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг  
хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг  
зохион байгуулах нэгдсэн удирдамжид орох нэмэлт,  
өөрчлөлтийг батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.5, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2018 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 1 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/26 дугаар тушаалаар баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулах нэгдсэн удирдамж”-д оруулах нэмэлт, өөрчлөлтийг хавсралтаар баталсугай.

2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулах нэгдсэн удирдамжид орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд оролцогч талуудын хооронд байгуулах гэрээний загвар, тайлангийн маягтуудад шаардлагатай өөрчлөлтийг оруулан баталж, мөрдүүлэхийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /Б.Нямдаваа/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Ц.Амартөгс/-т даалгасугай.

САЙД

  
С.ЧИНЗОРИГ

С.ЧИНЗОРИГ

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ХӨДӨЛМӨР  
ЭРХЛЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ НЭГДСЭН  
УДИРДАМЖИД ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТҮҮД

Нэг. Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд:

- 1.1. 2.1.3.3 “Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах мэргэжлийн сургалтын эрх бүхий байгууллагуудын жагсаалтыг жилд 2 удаа гаргана”,

Хоёр. Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд:

- 2.1. 2.2.1.1-д “Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг хөтөлбөрийн 4.1-д заасан дарааллын дагуу арга хэмжээнүүдэд хамруулсны дараа олгоно”,
- 2.2. 2.2.3.12-т “Хөтөлбөрүүдэд заасан иргэний үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг борлуулах “Борлуулалтын цэг”-ийг аймаг, дүүргүүд тус бүрдээ нэгдсэн нэг цэгээр зохион байгуулж болно”,
- 2.3. 2.2.2.4-т “Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах эрх бүхий сургалтын байгууллагын жагсаалтыг гаргахдаа Бизнес инкубатор төвүүдийн нэгдсэн холбооны саналыг харгалзан жилд 2 удаа гаргана” гэж тус тус нэмэх.

Гурав. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд:

- 3.1. 2.3.1.1-ийг хасаад “Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь гарааны бизнесийг дэмжих арга хэмжээг зохион байгуулаадаа хөтөлбөрийн энэхүү арга хэмжээнд хамруулах хүний тоо, хуваарилсан хөрөнгөөс шалтгаалан жилд 1-2 удаа зохион байгуулна”,
- 3.2. 2.3.1.2-ийг “Хөтөлбөрийн гарааны бизнесийг дэмжих арга хэмжээнд хамруулах хүний тоо, хуваарилсан хөрөнгөөс шалтгаалан Улаанбаатар хотод Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар дүүргүүдийн хэмжээнд нэгтгэж, зохион байгуулна”,
- 3.3. 2.3.1.4-т “Шалгарсан багуудын үйл ажиллагаа тогтвожиж, бизнесийн ашгаа хүртэж эхэлтэл /3 сар орчим/ бизнесийн зевлөх /ментор/-үүдтэй хамтарч ажиллах гэрээний загварыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар батална”,

Дөрөв. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд:

- 4.1. 2.4.1.3-т “36 сарын дотор”,

Тав. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд:

- 5.1. 2.5.2.4-д “Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь хөтөч, дохионы хэлмэрч, чиглүүлэгч бэлтгэх орон зайн чиг баримжааны сургагч багштай гэрээ байгуулж, ажиллана. Хөтөч, дохионы хэлмэрч, чиглүүлэгч болон орон зайн чиг баримжааны сургагч багш нь тухайн иргэнд зарцуулах цаг нь 80 цагаас, харин жилд нийт 800 цагаас хэтрэхгүй байна”,
- 5.2. 2.5.5.8-д “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт нийцүүлэн мэргэжлийн ур чадварын тусгайлсан сургалтыг Улаанбаатар хотоос алслагдсан З дүүрэг нь “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”-ийн 5.4.2-т заасны дагуу зохион байгуулна”,
- 5.3. 2.5.7-д “тохируулгатай” гэснийг хасах,
- 5.4. 2.5.7.3-ийг “Уг арга хэмжээнд хамрагдах байгууллагуудыг өргөжүүлэх, ур дүнг сайжруулах, ажлын байрыг нэмэгдүүлсэн байдлыг нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөөр тооцно”,
- 5.5. 2.5.7.4-т “Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь шалгарсан төслийдийг хэрэгжүүлэх чиглэлээр төсөл хэрэгжүүлэгчтэй гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллана”,
- 5.6. 2.5.7.5-д “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөл”-өөс санал болгосон төлөөллийг төсөл сонгон шалгаруулах үнэлгээний хороонд оролцуулахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь шийдвэрлэнэ,
- 5.7. 2.5.7.6-д “Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангасан, мөн Хөгжлийн бэрхшээлтэй ажил олгогч байвал төсөл сонгон шалгаруулалтад давуу тал болно”,
- 5.8. 2.5.7.7-д “Хөтөлбөрөөр олгож буй санхүүгийн дэмжлэгт хамрагдсан аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын хэрэгжүүлсэн төслийг гүйцэтгэлийн үр дүнд суурилан 24 сарын дараа дахин хамруулж болно” гэж тус тус нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулах зэрэг болно.

-----o0o-----